

ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын усан замын тээвэр 1950-иад оноос үүсэн хөгжиж, ЗХУ-аас /хуучин нэрээр/ импортолж буй өргөн хэрэглээний бараа, шатах тослох материал бусад ачааг 1 чирэгч хөлөг онгоц, 3 чиргүүл /нэг нь шингэн ачааны/ онгоцоор Ханх, Хатгал боомтын хооронд Хөвсгөл нуураар тээвэрлэхийн зэрэгцээ Ханх сум, Хатгалын хооронд зорчигч /20 орчим хүн/ мөн тээвэрлэж байв.

Улс орон зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэн 1990-ээд оноос ЗХУ-аас импортлох барааны ачаа эргэлтгүй болсон, мөн байгаль орчны асуудлаас болж усан замын тээвэр 2000 оныг дунд үеийг хүртэл зогссон билээ.

Өнөөгийн байдлаар хувийн хэвшлийнхэн буюу иргэн, хуулийн этгээдүүд жижиг, бага оврын усан замын тээврийн хэрэгслийг хөрш орнуудаас импортлон оруулж ирэн амрагч, жуулчдад усан замын тээврийн үйлчилгээг үзүүлж байна.

Усан замын тээвэр зогсонги байсан 1989-2009 онуудад тус улсын томоохон гол, мөрөн, нууруудад 10 хүрэхгүй тооны усан замын тээврийн хэрэгсэл тоологдож байсан бол 2019 оны техникийн үзлэг тооллогоор улсын хэмжээнд 156 усан замын тээврийн хэрэгсэл, үүнээс зөвхөн Хөвсгөл нуурт иргэд, аж ахуйн нэгж байгууллагын 80 гаруй усан замын тээврийн хэрэгсэл тоологдсон байна.

Эдгээр тээврийн хэрэгслээр сүүлийн 5 жил (2014-2019) - д 387,9 мянган (2014 онд 45,4 мянга, 2015 онд 57,8 мянга, 2016 онд 41,8 мянга, 2017 онд 20,6 мянга, 2018 онд 25,7 мянга, 2019 онд 31,0 мянга) зорчигч тээвэрлэжээ.

Дурдсан хугацаанд усан замын тээврийн хэрэгслийн болон зорчигчийн тоо өссөн ч зорчигч тээвэрлэлтэд баримтлах тодорхой үнэ тарифгүй, тээвэрлэгч бүр өөр өөрсдийн үзэмжээр үнэ тарифаа тогтоож ирлээ.

Усан замын тээврийн хэрэгслийн хөвөлтийн улирлын үргэлжлэх хугацаа богинохон /45 хоног/, мөн зах зээлийн чөлөөт өрсөлдөөний үед усан замын тээврийн үйлчилгээний үнэ тарифыг усан замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зүгээс хатуу тогтоож болохгүй тул тухайн орон нутгийн хүн амын амьжиргааны түвшин, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, шатах тослох материалын зардал болон тээврийн хэрэгслийн элэгдэл хорогдол, сэлбэг хэрэгслийн өртөг, зорчигчийн аюулгүй байдлыг хангах хүн нэг бүрийн хамгаалах хэрэгслийн хангамж, элэгдэл хорогдол, тээврийн хэрэгслийн ба зорчигчийн амь насны даатгал, ачаа, ачааны бэхэлгээ ачааны даатгалын өртөг зэрэг нөлөөлж болох бүх үзүүлэлтийг тооцож орон нутгийн засаг захиргаа, тээвэрлэгчид хамтран үнэ тарифыг тогтоох шаардлагатай.

Иймд Усан замын тээврийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.7-д усан замын зорчигч, ачаа тээвэрлэлтийн үнэ, тарифын аргачлалыг боловсруулах, хяналт тавих гэж заасны дагуу дараах аргачлалыг боловсруулав.

Усан замын зорчигч, ачаа тээвэрлэлтийн
үнэ, тарифын аргачлалын төсөлд хийсэн
нөлөөллийн шинжилгээ

1. Үнэ, тарифын аргачлал боловсруулах үндэслэл, шаардлага

Монгол Улсын Их Хурлаас Усан замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2017 оны 05 дугаар сарын 25-ны өдөр баталсан ба уг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.7-д Усан замын зорчигч, ачаа тээвэрлэлтийн үнэ, тарифын аргачлалыг усан замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална / гэсэн заалтыг үндэслэн энэхүү аргачлалыг Захиргааны ерөнхий хууль, Хууль тогтоомжийн тухай хууль, бусад холбогдох хуульд нийцүүлэн боловсруулав.

2. Үнэ, тарифын аргачлалын төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Аргачлалын төсөл нь нийтлэг үндэслэл, тээвэрлэлтэд баримтлах үнэ, тариф, аврах, чирэх ажиллагааны үед баримтлах үнэ, тариф, зорчигч, тэдний тээш тээвэрлэхэд баримтлах үнэ, тариф, үнэ, тарифын талаар тээвэрлэгч, ачаа илгээгч, ачаа хүлээн авагчид болон зорчигчдын хүлээх хариуцлага /торгууль/, үнэ, тарифтай холбогдуулан баримт /акт/, гомдол, нэхэмжлэл гаргах үндэслэл гэсэн 6 хэсгээс бүрдэнэ.

Усан замын зорчигч, ачаа тээвэрлэлтийн үнэ, тарифын аргачлал нь ачаа болон зорчигч тээвэрлэх үнэ, тариф тогтоох асуудлыг хамаарах бөгөөд мөн усан замын тээврийн хэрэгслийг эзэмшигч, өмчлөгч, түрээслэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад гарын авлага болно. Мөн үнэ тарифт хяналт тавих усан замын тээврийн хяналтын улсын байцаагчийн үүрэг, хариуцлагыг тодорхойлж зохицуулна.

3. Техникийн шаардлага батлагдсаны дараа эрх, хууль ёсны ашиг сонирхол нь аливаа байдлаар хөндөгдөж болохуйц бүлгийг тодорхойлох

Усан замын зорчигч, ачаа тээвэрлэлтийн үнэ, тарифын аргачлалын төслийг тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон харъяа Далайн захиргааны вэбсайтад нийтлүүлж усан замын тээврийн үйлчилгээ үзүүлж буй нийт иргэд, хуулийн этгээдүүд болон Хөвсгөл нуурт усан замын тээврийн үйлчилгээ үзүүлж буй иргэд, хуулийн этгээдийн дунд хэлэлцүүлж саналыг авч тусгасан болно.

Усан замын зорчигч, ачаа тээвэрлэлтийн үнэ, тарифын аргачлалын төсөл батлагдсаны дараа усан замын тээврийн хэрэгслээр ажил, үйлчилгээ эрхэлж буй иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол ямар нэг байдлаар хөндөгдөхгүй.

4. Хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан, өрсөлдөөнийг хязгаарласан, эдийн засаг, нийгмийн болон бусад үйл ажиллагаанд саад хориг учруулсан, аливаа хүнд суртал, авлига гарах нөхцөл боломж бүрдүүлсэн байж болзошгүй зохицуулалт агуулж байгаа эсэх

Усан замын зорчигч, ачаа тээвэрлэлтийн үнэ, тарифын аргачлал нь хүний эрх, эрх чөлөө, өрсөлдөөнийг хязгаарласан, эдийн засаг, нийгмийн болон бусад үйл

ажиллагаанд саад хориг учруулсан, аливаа хүнд суртал, авлига гарах нөхцөл боломж бүрдүүлсэн байж болзошгүй зохицуулалт агуулаагүй болно.

Аргачлалд ялгаварлан гадуурхсан эсхүл аль нэг бүлэгт давуу байдал үүсгэсэн, жендерийн эрх тэгш байдлыг хөндсөн, дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөөлсөн, хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдөл бий болгосон заалтыг тусгаагүй болно.

Мөн аль нэг аж ахуйн нэгжид, ялангуяа зах зээлд шинээр орж ирж байгаа иргэн, аж ахуйн нэгжүүдийн хувьд бэрхшээл, хүндрэл бий болгох, төрийн байгууллага болон бусад иргэн, хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт ачаалал бий болгох, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг зогсооход хүргэсэн, хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлсөн зохицуулалтыг агуулаагүй болно.

5. Тухайн асуудлыг зохицуулж байгаа урьд нь батлагдсан шийдвэр байгаа эсэх

Усан замын зорчигч, ачаа тээвэрлэлтийн үнэ, тарифын аргачлалын шаардлагад тусгагдсан харилцааг өмнө нь зохицуулсан ямар нэгэн батлагдсан шийдвэр байхгүй болно.

6. Усан замын зорчигч, ачаа тээвэрлэлтийн үнэ, тарифын аргачлалыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөц, техник, эдийн засгийн тооцоо

Иймд тавигдаж буй өнөөгийн шаардлагын дагуу “Усан замын зорчигч, ачаа тээвэрлэлтийн үнэ, тарифын аргачлал”-ын төслийг шинээр боловсруулсан бөгөөд түүнийг хэрэгжүүлэхэд хүний нөөц, техникийн болон эдийн засгийн нэмэлт зардал гарахгүй болно.

САЙД

Л.ХАЛТАР

УСАН ЗАМААР ЗОРЧИГЧ, АЧАА ТЭЭВЭРЛЭЛТИЙН ҮНЭ, ТАРИФ ТОГТООХ АРГАЧЛАЛ

Нэгдүгээр бүлэг

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү аргачлалын зорилго нь усан замын тээврийн хэрэгслээр гол мөрөн нуурт зорчигч, ачаа, тээш, шуудан тээвэрлэхэд баримтлах үнэ тариф тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Зорчигч, ачаа, тээш, шууданг усан замын тээврийн хэрэгслээр тээвэрлэх үнэ өртөг, хураамжийг усан замаар тээврийн үйлчилгээ эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллага (цаашид “тээвэрлэгч” гэх) тухайн орон нутгийнхаа хүн амын амьжиргааны түвшин, хөдөлмөрийн хэлсний доод хэмжээ, өөрийн өртөг, бусад нөхцөл байдлыг харгалзан орон нутгийн засаг захиргаа болон орон нутгийн тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн Монгол Улсын Иргэний хууль, бусад холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн тогтооно.

1.3. Тээвэрлэгчээс тогтоосон үнэ өртөг, хураамжийг орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэн, боомт, зогсоол дээр ил топд байршуулж, сонирхсон иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, хүмүүст мэдээлнэ.

1.4. Усан замын тээврийн хэрэгсэл чирэх, чирүүлэх, ачаа тээвэрлэлттэй холбогдсон нэмэгдэл ажиллагааны болон ачих буулгах ажиллагааны хураамж, урамшуулал, торгууль, аж ахуйн үйл ажиллагааны бусад ажлын төлбөр хураамжийг тээвэрлэгчид Монгол Улсын Иргэний хууль, бусад холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гэрээгээр зохицуулна.

Хоёр. Тээвэрлэлтэд баримтлах үнэ, тариф

2.1. Тээвэрлэгч дараахь үнэ өртгийг орон нутгийн засаг захиргаа, орон нутгийн тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтооно. Үүнд:

- 2.1.1. орон нутагт зорчигч, ачаа, тээш, шуудан тээвэрлэх үнэ өртөг, мөн гол, мөрөн, нуурын хоолой гатлах татлага онгоцны үнэ өртгийг;
- 2.1.2. усан замд шинээр чиглэл нээж ачаа, зорчигч тээвэрлэх;
- 2.1.3. хөвөлт (навигац) -ийн улиралд хөнгөлөлттэй үнэ өртгөөр зарим чиглэлд зорчигч, ачаа, тээш, шуудан тээвэрлэх буюу усан замын тээврийн хэрэгсэл чирэх;
- 2.1.4. онц чухал хэрэгцээтэй бус ачаа ачих буулгах ажлын хураамж, түүнчлэн усан замын тээврийн хэрэгсэл боомт, зогсоолд зогссоны хураамж;
- 2.1.5. усан замын тээврийн хэрэгсэл боомт, зогсоолд орж гарсны хураамж;
- 2.1.6. зайны үнэ өртөг тооцоолох болон урамшуулал, торгууль хураамж, үнэ өртгийг хэрэглэх аргачлал.

2.2. Тээвэрлэгч дараахь үнэ, өртгийг өөрөө тогтооно:

2.2.1. зорчигч тээвэрлэсний болон ачааг ачиж буулгасны дараа усан замын тээврийн хэрэгсэлд цэвэрлэгээ хийх, ачаа ачих, бэхлэхэд зориулагдсан хаалт, хашлага, тавцан болон бусад хэрэгслүүдийг барьж байгуулах, тоноглох, буулгах ажлын, мөн туслах ажлын хураамж;

2.2.2. тусгай бэхэлгээ шаарддаг том оворын, хүнд жингийн ачаа болон амьд амьтан тээвэрлэхэд зориулагдсан усан замын тээврийн хэрэгслийн тоног төхөөрөмж, тоноглол хэрэгслүүдийн хураамж;

2.2.3. боомт, зогсоол, агуулах, ачих буулгах тоног төхөөрөмж, хэрэгслүүд болон автомашин богино хугацаагаар ашигласны хураамж;

2.2.4. зорчигчдод ор дэрний цагаан хэрэглэл олгосны хөлс, ачаа зөөгчдийн хөлс, хураамжууд, тасалбарыг урьдчилан худалдаалсны болон гэрт нь хүргэж

үйлчилсний хураамж, гар тээш хадгалсны хураамж, зорчигчдыг зочид буудлын ор хоногоор үйлчилсний г.м болон энэ зүйлд тусгагдаагүй бусад үйлчилгээний хураамжийг тогтооно.

2.3. Ачаа илгээгч нь ачаагаа тээвэрлэлтэд хүлээлгэн өгөх үедээ бэлэн мөнгөөр, эсвэл гэрээнд заасан хэлбэрээр ачаа тээвэрлүүлсний хөлсийг тээвэрлэгчид төлнө.

2.4. Тээвэрлэгч үнэт цэнэтэй гэж зарласан зарим ачааг тээвэрлэлтэд хүлээн авч болох ба зарласан үнэ цэнэ нь ачааны бодит өртгөөс хэтрэхгүй байна. Тээвэрлэгч ба ачаа илгээгчийн хооронд ийм ачааны өртгийн талаар маргаан гарсан тохиолдолд хөндлөнгийн шинжээчид тодорхойлох ба энэ тухай акт үйлдэнэ.

2.5. Усан замын тээврийн хэрэгсэлд эвдрэл, гэмтэл гарсан шалтгаанаар буюу усны гүн багассанаас усан замын тээврийн хэрэгслийг бүрэн даацаар нь ачаалах боломжгүй бол зохих акт үйлдэж, ачсан ачааны бодит тоо ширхэгээр тооцоолон тээврийн хөлсийг авна.

2.6. Тээврийн хөлсөнд хамаарах бүх төлбөрийг ачаа хүлээн авагч эсвэл ачаа илгээгч барагдуулах хүртэл Тээвэрлэгч ачааг түүнд олгохгүй байж болно.

2.7. Тээвэрлэгч тээвэрлэлтэд хүлээн авсан ачааг хүргэх боомт, зогсоолыг ачаа илгээгчийн шаардлага, хүсэлтээр өөрчлөх бол анх товлосон боомт, зогсоолыг өөрчлөх хүсэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас тээвэрлэж буй ачааны тонн тутмаас 30000 төгрөгийн торгууль авч ачааны хаягыг солино.

2.8. Газрын тос, шатахууны төрлийн ачааг тээврийн дагалдах шинэ баримт үйлдэхгүйгээр анхны заасан боомт, зогсоолыг өөрчлөх ба нийт туулсан бодит замыг тээврийн хөлсөнд шингээж тооцно.

2.9. Байгалийн болон давагдашгүй аливаа хүчин зүйлийн улмаас, эсвэл усан замын тээврийн хэрэгсэл сул зогсохоос урьдчилан сэргийлэх үүднээс анхны товлосон боомт, зогсоол өөрчлөгдсөн бол торгууль төлөхгүй.

2.10. Түргэн муудаж гэмтэх ачааг хүргэхээр товлосон боомт, зогсоолыг тухайн ачааны чанарын гэрчилгээ, баталгаанд заасан хугацаанд шинэ боомт, зогсоолд хүргэх боломжтой тохиолдолд л өөрчилнө.

2.11. Аливаа ачааг тохиролцсоны үндсэн дээр буцааж тээвэрлэж болно. Иргэд гэр ахуйн эд барааг хүргүүлэхээр товлосон боомт, зогсоолоо өөрчлөх хүсэлт гаргавал Тээвэрлэгч торгууль авахгүйгээр өөрчилнө.

2.12. Хүрэлцэн ирсэн ачааг боомт, зогсоолд ирсэн өдрийг тооцохгүйгээр нэг хоногийн хугацаанд үнэ төлбөргүй хадгална. Үүнээс хэтэрвэл зохих хөлс авна. Тээвэрлэгчийн буруугаас ачаа олголт саатсан бол ачааг хадгалсны хөлс авахгүй.

2.13. Ачаа хүлээн авагчид бичгээр мэдээлсэн буюу ачаа хүлээн авагчдад нийтэд нь харагдахаар боомт, зогсоол дээр ил тод мэдээлснээс хойш нэг хоногийн дараа ачаа хадгалсны хөлсийг нэмэгдүүлж тооцно.

2.14. Тээвэрлэгч ачааг хүлээн авагчид нь хүргэх буюу хүлээлгэн өгөх боломжгүй бол, мөн ачааг тээвэрлэлтэд хугацаанд нь хүлээн авсан боловч аялалын замд саад бэрхшээл гарч, удаан хугацаагаар замдаа саатахаар бол Тээвэрлэгч энэ тухай 5 хоногт багтаан ачаа илгээгч ба ачаа хүлээн авагчид мэдэгдэж, ачаа хүлээн авагчийн зардлаар төмөр зам, автотээврийн хэрэгслээр хүлээн авах боомтод хүргэх арга хэмжээг авах буюу ачааг өөр байгууллагад шилжүүлэн өгнө.

2.15. Усан замын тээврийн хэрэгслээс ачааг хүлээн авах, буулгах хугацаа, түүнчлэн ачаа илгээгчийн шийдвэрийг хүлээх хугацаанд усан замын тээврийн хэрэгслийг сул зогсоосны хөлсийг буруутай талаас авах ба ачааг өөр газар, зогсоолд хүргэсэн тохиолдолд

ачааг буулгахад гарсан зардал, буулгасан боомт, зогсоолд ачаа хадгалсны хураамж, нэмэгдэл тээвэрлэлт болон ачааг борлуулсны зардлуудыг гаргуулна. Ачаа буулгах хугацаа дуусвал ачаа хүлээн авагчийн зардлаар ачааг буулгана.

Гурав. Аврах, чирэх ажиллагааны үед баримтлах үнэ, тариф

3.1. Аюул, осолд өртсөн усан замын тээврийн хэрэгсэлд тусламж үзүүлсний төлөө, үүний үр дүнд усан замын тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдал, тэдгээрийн дээр байсан ачаа эсвэл бусад үнэт зүйлсийг бүрэн буюу хэсэгчлэн хамгаалсан бол шагнал урамшуулал авна.

3.2. Тусламж үзүүлсний төлөөх мөнгөн шагнал урамшилд үйлчилгээний хөлсөөс гадна, тусламж үзүүлэх явцад гарсан бүх зардал орно. Мөнгөн шагнал урамшууллын хэмжээг талуудын гэрээ, хэлэлцээрээр, байхгүй тохиолдолд харилцан зөвшилцөж тодорхойлно.

3.3. Тусламж үзүүлсний төлөөх мөнгөн шагналын хэмжээ аварсан эд хөрөнгийн өртгөөс хэтэрч болохгүй.

3.4. Аврагдсан хүмүүс өөрсдийг нь аварсны төлөө шагнал урамшуулал төлөх албагүй. Гэхдээ хүмүүсийг аврах ажиллагаанд оролцсон этгээд, эд хөрөнгө аварсан этгээдтэй нэгэн адил эд хөрөнгө аварсны төлөөх нийтлэг шагнал урамшуулалаас хувь авч болно.

Дөрөв. Зорчигч, тэдний тээш тээвэрлэх үед баримтлах үнэ, тариф

4.1. Боомт, зогсоолын гар тээш хадгалах газар нь зорчигчдын гар тээшийг хүлээн авч тасалбар шаардахгүйгээр зохих хураамжийг авч хадгална.

4.2. Зорчигч хүсвэл тасалбарын үнийн зөрүүг урьдчилан төлж, илүү өндөр ангилалын суудалд аялалын замд шилжин сууж болно.

4.3. Зорчигчийн төлсөн суудлын өртгөөс бага өртөгтэй суудал зорчигчид олгосон бол өртгийн зөрүүг түүнд буцааж олгоно. Тухайн усан замын тээврийн хэрэгсэлд суудал олгох боломжгүй бол Тээвэрлэгч зорчигчийн шаардлагаар өөр усан замын тээврийн хэрэгсэлд зохих суудал түүнд олгоно.

4.4. Зорчигч аялалаас татгалзаж, усан замын тээврийн хэрэгсэл хөдлөхөөс 6 цагийн өмнө тасалбараа буцаасан бол үнийг нь бүрэн буцааж өгнө. Энэ хугацаанаас хожимдуулж гэхдээ усан замын тээврийн хэрэгсэл хөдлөхөөс өмнө тасалбараа буцаасан, түүнчлэн эмнэлгийн байгууллагаар баталгаажуулсан лавлагаатай, өвчний улмаас усан замын тээврийн хэрэгслээс хоцорсон зорчигчид тасалбарын үнийг буцааж олгоно. Аялалын замд өвчин эсвэл золгүй явдлын улмаас аялалаа цаашид үргэлжлүүлэхгүй болсон тохиолдолд тасалбарын үнийн зөрүүг тооцож зорчигчид буцааж олгоно.

4.5. Тээш хүрэлцэн ирсэн өдрийн дараа өдрөөс эхлэн тооцож 24 цагийн хугацаанд түүнийг хүргэсэн боомт, зогсоолд үнэ төлбөргүй хадгалах ба үүний дараа тээш хадгалсны хөлсийг авна.

4.6. Сарын дотор эзэн нь шаардаж аваагүй тээшийг баримт үйлдэж орон нутгийн засаг захиргаанд хүлээлгэн өгнө. Тээш нь хүрэлцэн ирэх хугацаа дууссанаас хойш 30 хоногийн хугацаанд ирээгүй бол зорчигч, түүнийг алдагдсан гэж үзэж үнэ, өртгийг төлөхийг Тээвэрлэгчээс шаардах эрхтэй.

4.7. Зорчигч илүү жинтэй гар тээш авч явбал илүү кг бүрт 3000 төгрөгийн торгууль төлнө. Зорчигч тасалбар худалдан авсан боомт, зогсоолоос хүрэх боомт, зогсоол хүртэл илүү кг жинтэй гар тээш тээвэрлэсэн өртгийг ачааны үнэ тарифаар тооцож төлнө.

4.8. Зорчигч торгууль төлөөгүй буюу илүү жинтэй гар тээш тээвэрлэсэн өртгийг төлөхгүй бол хуулиар тогтоосон журмаар түүнээс төлбөрийг албадан гаргуулна. Санал хүсэлтийн дэвтэр дэх бичлэг нь тээвэрлэх үйл ажиллагааны үед учирсан хохирол, торгууль төлөх тухай гомдол гаргах шаардлагыг үгүйсгэхгүй.

Тав. Үнэ, тарифын харилцаанд тээвэрлэгч, ачаа илгээгч, ачаа хүлээн авагчид болон зорчигчдын хүлээх хариуцлага

5.1. Ачаа илгээгч, ачаагаа тээвэрлэлтэд хүлээлгэн өгөхдөө тээврийн хөлсөө төлөөгүй бол ачаагаа тээвэрлэлтэд хүлээлгэн өгсөн өдрөөс хойш хугацаа хэтэрсэн хоног тутамд төлөөгүй мөнгөн дүнгийн нэг хувьтай тэнцүү хэмжээгээр, төлбөрөө бүрэн барагдуулах хүртэл тээвэрлэгчид торгууль төлөх ба ачаа тээвэрлэлтийг саатуулж, тээврийн хөлсөө цаг тухайд нь төлөөгүйн торгуулиас гадна усан замын тээврийн хэрэгслийн сул зогссон даац, зүтгэх хүчний торгуулийг төлнө.

5.2. Ачаа тээвэрлэх, эсвэл чирэх ажиллагаанд усан замын тээврийн хэрэгслээ бэлтгээгүй буюу гаргаж өгөөгүй тээвэрлэгч, мөн ачаагаа тээвэрлэлтэд бэлтгэж хүлээлгэн өгөөгүй, эсвэл хэт бага хэмжээгээр хүлээлгэн өгсөн ачаа илгээгч хүлээлгэн өгөөгүй буюу ачуулахаар бэлтгэсэн тээвэрлээгүй ачааны тээврийн хөлсний 25 %-ийг харилцан төлнө.

5.3. Ачаа ачиж буй боомт, зогсоолын эсвэл усан замын тээврийн хэрэгслийн удирдлагаас усан замын тээврийн хэрэгсэл дээр явагдаж буй ачих буулгах ажиллагааны талаар өгсөн заавар, зөвлөмжийг биелүүлээгүй тохиолдолд ажлыг зогсоон акт үйлдэж, усан замын тээврийн хэрэгслийг сул зогсоосны торгуулийг ачаа илгээгч эсвэл ачааг хүлээн авагчаас авна.

5.4. Ачааг тогтоосон хугацаанд нь хүргээгүй буюу хожимдуулсан тээвэрлэгч нь саатуулсан хоногоос хамааруулан тээврийн хөлсний 8% хүртэл торгуулийг ачаа хүлээн авагчид төлнө.

5.5. Тээвэрлэгчийн буруугаас зорчигчдын тээш хүргэх хугацааг хожимдуулсан, түүнчлэн хүрэлцэн ирсэн ачаа, тээшийг боомт, зогсоолын агуулахаас олгох ажлыг саатуулсан бол хожимдуулсан буюу саатуулсан хоногоос хамааруулан тээврийн хөлсний 3% хүртэл торгуулийг ачаа хүлээн авагч болон тээшийн тасалбар үзүүлэгчид төлнө.

5.6. Хүргэх хугацаа хожимдуулсны улмаас ачаа гэмтэж муудсанаас гарсан хохирлыг нөхөн төлөх нь ачааг хугацаанаас нь хожимдуулсны торгуулиас тээвэрлэгчийг чөлөөлөхгүй.

5.7. Тээвэрлэгч дараахь тохиолдолд ачаа, тээш хүргэх хугацааг хожимдуулсаны торгуулиас чөлөөлөгдөнө:

5.7.1. тээвэрлэгч урьдчилан сэргийлж, зайлуулж чадахааргүй нөхцөл байдал үүссэн болон давагдашгүй хүчин зүйлийн улмаас;

5.7.2. усан замын тээврийн хэрэгслийн хөдөлгөөн саатсан, удааширсан тухай мэдэгдлийг ачаа хүлээн авагчид өмнө нь хүргүүлсэн бол;

5.7.3. боомт, зогсоолд хүрэлцэн ирсэн тухайгаа мэдэгдсэнээс хойш нэг хоногийн дотор ачаа хүлээн авагч хугацаа хожимдож ирсэн ачаагаа аваагүй бол;

5.7.4. усан замын тээврийн хэрэгсэл боомт, зогсоолд хүрэлцэн ирснээс хойш 24 цагийн дотор ачаа хүлээн авагч ачаагаа буулгаагүй бол.

5.8. Ачаа тээвэрлэх үедээ учруулсан дараах хохирлыг тээвэрлэгч нөхөн төлнө:

5.8.1. ачааг алдаж үрэгдүүлбэл – алдсан ачааны бодит өртөгтэй тэнцүү хэмжээгээр;

5.8.2. зарласан үнэтэйгээр тээвэрлэлтэд хүлээн авсан ачааг алдаж үрэгдүүлсэн бол – зарласан үнэтэй тэнцүү хэмжээгээр;

5.8.3. зарласан үнэ нь бодит өртгөөс илүү байгаа гэдгийг нь тээвэрлэгч баталж чадвал – бодит өртгийн хэмжээгээр;

5.8.4. ачааг эвдэлж, гэмтээсэн бол түүний үнэ өртөг буурсан дүнгээр.

5.9. Тээвэрлэгчийн алдаж үрэгдүүлсэн буюу гэмтээсэн ачааны өртгийг бөөний, бэлтгэн нийлүүлэх буюу худалдан авах үнэ өртөг дээр нэмж:

5.9.1. ачаа, барааны үнэ өртөгт түүний сав баглаа боодлын үнэ өртөг ороогүй бол сав баглаа, боодлын үнэ;

5.9.2. анхны боомт, зогсоолд ачаа хүргэсэн болон хүрсэн боомт, зогсоолоос ачаагаа зөөхдөө гаргасан ачаа илгээгчийн нэмэгдэл зардлууд, эдгээр зардлууд нь барааны үнэ өртөгт ороогүй бол;

5.9.3. Тээвэрлэгчийн алдаж үрэгдүүлсэн, эвдэлж гэмтээсэн ачааны нөхөн төлбөрийг нийлүүлэгч /ачаа илгээгч/-ийн данс тооцоог үндэслэн эсвэл данс, тооцоог орлож болох бусад баримтыг үндэслэн тооцож гаргана. Иргэдийн ачааны үнэ, өртгийг хүрэх боомт, зогсоолд ачааг хүлээлгэн өгөх үед мөрдөж буй зах зээлийн жижиглэн худалдаалах үнээр тодорхойлно.

5.10. Тээвэрлэгч тээвэрлэлтэд хүлээн авсан ямар нэгэн ачааг хэн нэгэн этгээд өөрийн хэрэгцээнд ашигласан бол буруутай этгээдэд тээвэрлэгч хариуцлага хүлээлгэж ачааны үнэ өртгийг хоёр нугалж төлүүлнэ.

5.11. Ачих буулгах ажиллагааны улмаас чингэлэгийг саатуулах, түүнийг цаг тухайд нь буцаагаагүй бол аль буруутай тал нь цагаар тооцож торгууль төлнө. Торгуулийн хэмжээг гэрээгээр тохиролцоно

5.12. Тээврийн дагалдах баримтад ачааны нэр төрөл, тоо ширхэг, хэмжээ, жин, түүнчлэн тээвэрлэхийг хориглосон ачаа болон тээвэрлэх үед аюулгүйн ба урьдчилан сэргийлэх онцгой арга хэмжээг авахыг шаардсан ачааг нэр төрөл, шинж чанарыг нь буруу зааж хүлээлгэн өгсөн ачаа илгээгчид торгууль ногдуулах ба тээвэрлэгчид учруулсан хохирлыг барагдуулна.

5.13. Тээврийн дагалдах баримтад ачааны тээврийн хөлсийг багасгах үндэслэл болсон буруу мэдээллийг оруулсан ачаа илгээгчээс тээврийн хөлс авахаас гадна ачаа илгээгчийн анх мэдүүлснийг үндэслэн тооцсон ачааны хөлс ба ачааны жинхэнэ нэр төрөл, бодит тоо ширхэг, хэмжээгээр тооцогдох байсан мөнгөн дүнгийн зөрүүг хоёр дахин нугалж торгууль авна.

5.14. Ачаа илгээгч усан замын тээврийн хэрэгслийг сул зогсоосны торгууль төлөх ба тээврийн дагалдах баримтад хил, гааль, хорио цээр ба засаг захиргааны бусад дүрэм, журмаар тогтоосон баримтуудыг хавсаргаагүй буюу эдгээр баримт нь буруу зөрүү, бүрэн гүйцэд бус байснаас үүсэн гарсан зардал, алдагдлыг тээвэрлэгчид нөхөн төлнө.

5.15. Ачаа илгээгч эсвэл ачаа хүлээн авагчийн буруугаас ачаа ачих, буулгах үед болон ачаа ачих, буулгахыг хүлээж усан замын тээврийн хэрэгслийг тогтоосон хугацаанаас илүүгээр саатуулсан тохиолдолд тээвэрлэгч өөрийн тогтоосон хэмжээгээр түүнээс торгууль авна.

5.16. Нэг ачаа илгээгч эсвэл ачаа хүлээн авагч ачаагаа ачих буулгахдаа усан замын тээврийн хэрэгслийг удаа дараа сул зогсоосон бол тээвэрлэгч 48 цагаас илүү саатуулагдсан усан замын тээврийн хэрэгслийн сул зогссоны торгуулийн хэмжээг хоёр дахин нэмэгдүүлнэ.

5.17. Усан замын тээврийн хэрэгслийг сул зогсоосны болон чингэлэг саатуулсаны торгуулийг тээвэрлүүлэгч үл маргах журмаар төлнө. Усан замын тээврийн хэрэгслийг сул зогсоосны торгуулийг нэмэх тухай боомт, зогсоолдоо зарласан буюу усан замын тээврийн хэрэгслийн сул зогсолтыг хариуцах ачаа илгээгч ба ачаа хүлээн авагчид тусгайлан мэдэгдсэнээс хойш 24 цагийн дараа түүнийг мөрдөнө. Ачаа ачих буулгах үед усан замын тээврийн хэрэгслийг тогтоосон хугацаанаас нь илүүгээр удаа дараа саатуулсан буруутай этгээдэд захиргааны хариуцлага хүлээлгэнэ.

5.18. Ачаа хүлээн авагчийн тоног төхөөрөмж, хэрэгслээр ачааг буулгах ажиллагааг гүйцэтгэсний дараа усан замын тээврийн хэрэгслийг цэвэрлээгүй бол ачаа хүлээн авагч

цэвэрлэгээний ажлын хөлсийг хоёр нугалж тээвэрлэгчид төлнө. Тээвэрлэгч ачаа хүлээн авагчийн цэвэрлээгүй усан замын тээврийн хэрэгслийг цэвэрлэхээс татгалзах, усан замын тээврийн хэрэгслийг цэвэрлэх хүртэл цэвэрлэгээнд сул зогссоны торгуулийг ачаа илгээгчээс авна. Боомт, зогсоол дээр бага хэмжээний ачаа буулгасны дараа усан замын тээврийн хэрэгслийг цэвэрлэгээг тээвэрлэгч өөрийн хөрөнгөөр гүйцэтгэнэ.

5.19. Ачаа илгээгч буюу ачаа хүлээн авагчийн тоног төхөөрөмж, хэрэгслээр ачих, буулгах үед усан замын тээврийн хэрэгслийн эд зүйлс, багаж хэрэгсэл тоног төхөөрөмж болон чингэлэгийг гэмтээсэн бол усан замын тээврийн хэрэгслийн гэмтсэн хэсгүүдийг засварласан өртгийг 3 нугалсан хэмжээний торгуулийг ачаа илгээгч буюу ачаа хүлээн авагч, тээвэрлэгчид төлнө. Тээвэрлэгч усан замын тээврийн хэрэгслээрээ боомт, зогсоолын байгууламж болон эргийн тоног төхөөрөмж, хэрэгсэл, хөвөгч хэрэгслийг гэмтээсэн бол тэдгээрийг засварлуулсан өртгийг 3 нугалсан хэмжээний торгууль төлнө.

5.20. Ачаа илгээгч буюу ачаа хүлээн авагч торгуулиас гадна ачаа ачих буулгах үед болон ачаалах, савлах баглах горим зөрчсөн, бэхэлгээг буруу хийсэн тэдний буруугаас усан замын тээврийн хэрэгсэл эвдэрч гэмтсэнээс учирсан зардал, хохирлыг тээвэрлэгчид төлнө.

5.21. Тээвэрлэгч өөрөөс нь үл хамаарах, урьдчилан сэргийлж зайлуулах боломжгүй нөхцөл байдлуудын улмаас чирч буй буюу чирэгдэж буй усан замын тээврийн хэрэгсэлд хор хохирол учирсан гэдгийг баталж чадвал хариуцлага хүлээхгүй.

5.22. Чирүүлэх усан замын тээврийн хэрэгслийн бэлэн бус байдлаас чирэх усан замын тээврийн хэрэгслийг сул зогсоосон, чирэх ажиллагааны хөлс төлөлтийг саатуулсан, хүрэх боомт, зогсоолд усан замын тээврийн хэрэгслийг хүлээн авах ажлыг саатуулсан усан замын тээврийн хэрэгслийн эзэн буюу хүлээн авагчаас тогтоосон үнэ тарифын дагуу үл маргах журмаар торгууль суутгана.

5.23. Тасалбаргүй зорчиж байгаа буюу тасалбарт зааснаас илүү өндөр ангилалын суудалд зорчиж буй зорчигчийг тогтоосон хэмжээгээр торгоно. Торгууль төлөхөөс болон аялалаа цааш нь үргэлжлүүлэх тасалбар авахаас татгалзсан зорчигчийг ахмад хууль тогтоомжийн дагуу тасалбаргүй зорчсоны торгуулийг түүнээс албадан авч аялалын дагуух анхны боомт, зогсоолд буулгана.

5.24. Зорчигчийн худалдан авсан тасалбарт заасан суудлыг усан замын тээврийн хэрэгсэлд олгоогүй, түүнд санал болгосон өөр суудлаас зорчигч татгалзсан бол тээвэрлэгч тасалбарын үнэ, нэмэгдэл үнээс гадна тогтоосон үнэ тарифын дагуу торгууль зорчигчид төлнө.

Зургаа. Үнэ, тарифтай холбогдуулан баримт /акт/, гомдол ба нэхэмжлэл гаргах үндэслэл

6.1. Тээвэрлэгч өргөдөл, гомдлыг хянан үзээд, түүнийг хүлээн авсан өдрөөс хойш дараахь хугацаанд өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн буюу хүлээж авахгүй тухайгаа хүсэлт гаргагчид мэдэгдэнэ. Үүнд:

6.1.1. торгууль, урамшуулал болон тээврийн хөлсний маргаантай холбогдсон өргөдөл, гомдлыг – 45 хоногийн дотор,

6.1.2. бусад бүх тохиолдолд – 3 сарын дотор.

6.2. Өргөдөл, гомдолд хүлээн зөвшөөрсөн мөнгөн дүн буюу нэхэмжлэлд олгосон мөнгөн дүнгээс 4%-ийн татварыг тээвэрлэгчээс авна. Мөнгө төлсөн буюу шилжүүлсэн өдрөөс дараахь хугацааг баримтлан хүү тооцно. Үүнд:

6.2.1. тээврийн хөлс ба нэмэгдэл хураамжийг буцаах тухай өргөдөл, гомдлыг – ачаа буюу тээлийг олгох өдрөөс,

6.2.2. бусад бүх тохиолдолд - өргөдөл, гомдол гаргасан өдрөөс.

6.3. Тээвэрлэгчээс тээвэрлэлт буюу чирэх, чирүүлэх ажиллагаатай холбогдуулан ачаа илгээгч, ачаа хүлээн авагч болон чирэх, чирүүлэх усан онгоцны эздэд тавьсан

шаардлагуудад мөн тийм хэмжээгээр хүү төлнө. Энэ тохиолдолд тээвэрлэгч зохих мөнгөн дүнг төлөх ёстой өдөрт нь төлөх тухай шаардлагыг бичгээр гаргасан өдрөөс эхлэн хүү тооцно.

6.4. Ачааг олгосон өдрөөс хойш нэг сарын дотор илүү төлсөн ачааны хөлсийг эргүүлэн өгсөн, түүнчлэн ачааны хөлсийг дутуу төлсөн мэдэгдэл авсан өдрөөс хойш мөн хугацаанд дутууг гүйцээсэн бол хүү тооцохгүй.

6.5. Тээврийн хөлсний илүү төлөлтийг буцааж авах түүнчлэн тогтоосон шагнал урамшууллыг нөхөн төлөх тухай өргөдөл, гомдлыг Тээвэрлэгч шүүхийн бус журмаар шийдвэрлэнэ. 100.0 хүртэл мян. төг илүү төлсөн тээврийн хөлсийг буцаах, шагнал урамшуулал олгох тухай өргөдөл, гомдлыг Тээвэрлэгч шийдвэрлэх ба давж заалдах эрхгүй. 100.0 мян. төг-өөс илүү төлсөн тээврийн хөлсийг буцаах, шагнал урамшуулал олгох тухай Тээвэрлэгчийн шийдвэрийн талаар харъяалах дээд байгууллагад нь нэг сарын дотор гомдол гаргаж болно.

6.6. Харъяалах дээд байгууллага нь илүү төлсөн тээврийн хөлсийг буцаах, шагнал урамшуулал олгох тухай Тээвэрлэгч хүсэлт гаргагчид тогтоосон хугацаанд нь хариу өгөөгүй бүх өргөдөл, гомдлыг мөнгөн дүнгийн хэмжээнээс үл хамааруулан мөн хугацаанд шийдвэрлэнэ. Өргөдөл, гомдлын талаарх харъяалах дээд байгууллагын шийдвэр нь эцсийнх бөгөөд хүсэлт гаргагчид нэг сарын дотор мэдээлнэ.

6.7. Энэхүү аргачлалыг Тээвэрлэгч, ачаа илгээгчид болон ачаа хүлээн авагчид ажил үйлчилгээнийхээ үнэ, тарифыг тогтоохдоо баримтална.